



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/60

Бүрэн сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний
дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Пүрэв-Очир
(Засаг даргын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: Н.Энхжаргал (Татварын улсын байцаагч)
П.Цэцэнбаяр
(Засаг даргын Тамгын газрын төсвийн Нягтлан бодогч)
Ц.Лхагва
(Төхөм 1-р багийн Засаг дарга)


Нарийн бичгийн дарга: Б.Батхүү
(Газрын даамал)

2.Дуудлага худалдааг Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын дагуу зохион байгуулахыг дуудлага худалдааны ажлын хэсгийн ахлагч (Ж.Пүрэв-Очир)-д үүрэг болгосугай.

3.Дуудлага худалдаанд ялсан ялагчтай гэрээ байгуулж, үнийг төсөвт бүрэн оруулах, ялагчаар тодроогүй иргэн, аж ахуй нэгжийн барьцааг буцаан олгох ажлыг гүйцэтгэхийг Газрын даамал (Б.Батхүү), Засаг даргын Тамгын газрын төсвийн Нягтлан бодогч (П.Цэцэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Отгоншигт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

412305135